

Дээрх түүхэн баримтуудаас үзэхэд дэлхий нийтийн шоронгийн хөгжлийн түүхийг түүнд гарсан өөрчлөлт, шинэчлэлүүдийг харгалзан 3 үндсэн үе шатанд хуваан авч үздэг нийтлэг ойлголт нэгэнт тогтжээ. Үүнд:

- Эртний үе буюу МЭӨ 5000 жилээс МЭ V зуун хүрэлх хугацааг

- Дунд үе буюу Дундад зуунаас XVII зуун хүртэлх хугацааг

- Өнөө үе буюу XVII зуунаас өнөөг хүртэлх хугацааг хамруулан авч үзэж байна.

* * *

Б.БАЯСГАЛАН



Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Аюулгүй
байдлын тэнхимийн
эрхлэгч, хурандаа

БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЙЛГОЛТ

Байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулах нь "Аюулгүй байдал", "Аюулгүй байдлыг хангах" гэх мэт ойлголтыг тайлбарлаж анхны эх үүсвэрийг зөв тодорхойлж, үйл ажиллагааныхаа чиг хандлагыг тогтоож, аюулгүй албаны оновчтой бүтэц бүрдүүлснээс ихээхэн хамаарна. Хүн төрөлхтний хөгжил бол тэмцлийн түүх, өөрийгөө аливаа аюулаас хамгаалах, эзлэн түрэмгийлэх, дайн ба энхийн түүх билээ. Аюулгүй байдлаа хангах асуудал хүн төрлөхтний түүхийн бүх шатанд байсан одоо ч байгаа. Харин "Аюулгүй байдал" гэдэг нэр томъёо, ухагдахууныг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, албан ёсны хэл ярианд түүхийн харьцангуй сүүлийн үеэс хэрэглэгдэж ирсэн. "Аюулгүй байдал" гэсэн ойлголт XII зууны үеээс эхлэн бий болсон тухай зарим эх сурвалжид байгаа талаар Оросын эрдэмтэд өөрсдийн бүтээлдээ дурьдаж "Хүн өөрийгөө аливаа аюулаас хамгаалагдсан оюун санааны тайван амгалан байх нөхцөл" гэж тайлбарласан байна. Орос улсад "төрийн аюулгүй байдал" гэсэн ойлголтыг анх 1881 оны 08 дугаар сарын 14-нд батлагдсан "Олон нийтийн амгалан байдал, төрийн дэг журмыг

хамгаалах арга хэмжээний тухай”⁸⁰ дүрмэндээ тусгажээ. Мөн 1689 оны Английн Эрхийн тухай Билл Харт, Америкийн 1776 оны Тусгаар тогтнолын тунхаглал, Францын 1789 оны Иргэний эрхийн⁸¹ тунхаг зэрэг түүхэн баримт бичигт аюулгүй байдлын тухай зарим нэг ойлголтууд тусгагдсан байдаг.

Монголын эзэнт гүрний үед эзэн хаан, төрийн аюулгүй байдлыг Дотоод мянган бууу шадар хишигтэн хангах үүргийг гүйцэтгэдэг байсан тухай “Монголын нууц товчоо”-нд дурьджээ. Мөн эдийн засгийг хөгжүүлэхэд зам харилцааны аюулгүй байдлыг хангах, төрийн удирдлага, аливаа ажил хэргийг шуурхай саадгүй байлгах үүднээс өртөө замыг байгуулжээ. Чингис хааны төрийн бодлого нь анхандаа хөрш зэргэлдээ улсуудаар өөрийн байгуулсан улсаа зөвшөөрүүлэх, газар нутгийн аюулгүй байдлыг хангах, гадны болзошгүй аюулаас хамгаалахад чиглэгдэж байсан боловч тухайн зорилтууд тайван замаар бүтэх боломжгүй учир хүч хэрэглэх, цэргийн хүчээр байлдан дагуулах замаар зорилгоо хэрэгжүүлэхэд хүрсэн. Эдгээр түүхэн баримтаас үзэхэд түүхийн хөгжлийн эхэн үед аюулгүй байдлыг цэрэг дайны аюулгүй байдал, гадны халдлага түрэмгийллээс хамгаалагдсан байх хүрээнд ойлгож, тайлбарлаж байсан бол өдгөө хүн төрөлхтний

аюулгүй байдал хувь хүний хамгаалагдсан байдлаас эхэлнэ гэсэн үзэл баримтлалын шинэ чиг хандлага болгож хүний аюулгүй байдлыг цогцоор нь авч үзэх болжээ. Гэхдээ аюулгүй байдлын тухай ойлголтыг дотор нь төрийн, үндэсний аюулгүй байдал гэх мэтээр төрөлжүүлэн ангилж улс төрийн хэллэгэнд өнгөрсөн ХХ зууны эхэн үеэс хэрэглэж эхэлсэн тухай зарим эх сурвалжид тэмдэглэсэн байдаг. Тухайлбал: “Үндэсний Аюулгүй байдал” гэсэн нэр томъёо, хэллэгийг анх АНУ-ын ерөнхийлөгч асан Теодор Рузвелт 1904 онд хэрэглэсэн тухай тэмдэглэгдэн үлджээ.

Академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн толь бичиг”-т “аюулгүй байдал” гэдгийг “Тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх, эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төрийн, эдийн засгийн, нийгэмшлийн, цэргийн, экологийн, мэдээллийн бусад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм ба төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал”⁸² гэсэн нь аюулгүй байдлын ойлголтыг цаашид бүх талаар нарийвчлан судалж аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны онцлог ялгаатай байдлыг тогтоон шинжлэх ухааны үүднээс хандах шаардлагатайг энгийнээр товч тодорхой тайлбарлажээ.

Иймд “Аюулгүй байдал”, “Аюулгүй байдлыг хангах” зэрэг асуудлуудын ялгаа заагийг зөв тогтоон, үйл ажиллагааныхаа чиг хандлагыг зөв

1 Карпов В.И, Павлов Д.Б Основы теории обеспечения, безопасности общества и государства Москва 2010 г С 35-36

2 Т.Оюунчимэг Гэрч УБ 2013

⁸² С.Нарангэрэл “Эрх зүйн толь бичиг” 24

тодорхойлох нь үйл ажиллагаа явуулж байгаа бүх субъектуудын тулгамдсан асуудал мөн.

С.Нарангэрэлийн

тодорхойлолтоос үзэхэд "Аюулгүй байдал" гэдэг ойлголтыг дараах байдлаар ангилж төрөлжүүлэн судалж хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал: Глобал аюулгүй байдалд хүн төрөлхтний өмнө тулгамдсан экологи, эдийн засаг, хүнсний, хүн ам зүйн, цөмийн, соёл иргэншлийн болон тодорхой бүс нутаг, улс орны хэмжээний аюулгүй байдалд Үндэсний Аюулгүй байдал түүний хамгаалагдсан байдал гэх мэтээр төрөлжүүлсэн судалгаанууд тодорхой хүрээнд хийгдэж байна.

Харин бусад шинж чанартай аюул занал гэдэгт "Төр, нийгмийн аюулгүй байдал", "Байгууллагын аюулгүй байдал", "Хүний аюулгүй байдал", "Бизнесийн аюулгүй байдал" гэж төрөлжүүлэн, онцлогт нь тохирсон аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны оновчтой арга замыг тодорхойлох зүйтэй юм. Өнөөгийн нийгэм улс төрийн өөрчлөлтийн үр дүнд эрүүгийн нөхцөл хүндэрч, гэмт хэрэг зохион байгуулалттай үйлдэгдэж байна. Иймд хорих байгууллага болон албан хаагчдын аюулгүй байдлыг хангах тэдний хамгаалалтыг улам төгөлдөржүүлэхийг цаг үе шаардаж байна.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах гэдэг нь бол маш өргөн утгатай ойлголт юм. Байгууллагын эдийн засгийн болон бусад ашиг сонирхлыг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, түүнийг саармагжуулах, учирч болох хор хохирлыг боломжит

хэмжээгээр багасган хямралын түвшинд хүргэхгүй байлгаж чадах нөхцөл байдлыг хангасан бүтэц тогтолцоог **байгууллагын аюулгүй байдал** гэнэ.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь явуулж байгаа үйл ажиллагаанд гадны хүчин зүйл, хувь хүн, хуулийн этгээдээс учирж болзошгүй хор, аюулаас хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй эдийн засаг, эрх зүй, хүний нөөц, техникийн шинж чанартай харилцан уялдаатай иж бүрэн арга хэмжээний цогц ойголт юм.

Аюулгүй байдлыг хангах тогтолцооны үндсэн зорилго бол гадаад, дотоод сөрөг хүчин зүйлээс байгууллага түүний ашиг сонирхолд учирж болох хор, аюулыг аль болгох бага түвшинд байлгахад оршино. Энэхүү зорилт нь байгууллагын санхүү, эд материал, мэдээлэл, хүний нөөцөд учирж болох хор, хохиролыг нийгэм, эдийн засаг, эрх зүйн шинжтэй иж бүрэн арга хэмжээ хэрэгжүүлсэнээр хангагддаг.

Байгууллагын аюулгүй байдлыг хангах тогтолцооны чиг үүрэг нь:

-учирж болзошгүй аюулыг урьдчилан таамаглах

-урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах "сөрөг арга хэмжээ"

-үүссэн бодит хор, аюулыг илрүүлж, үнлэлт, дүгнэлт хийх

-үүссэн аюулыг зайлуулах талаар шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

-Аюулаас хамгаалах тогтолцоогоо байнга боловсронгуй болгож хөгжүүлж байх

Аюулаас хамгаалах тогтолцооны зохион байгуулалт нь дараах зарчмыг баримтлана:

- урьдчилан сэргийлэх нь нэн тэргүүний зарчим байна хууль ёсыг сахих
- хүч, хэрэгслийг цогцоор нь ашиглах
- байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагаа нь харилцан уялдаж зохицуулагдсан байх
- нууцлал, ил тод байдлын харилцан тэнвэрт байдлыг хангах
- эдийн засгийн үр өгөөжтэй байх
- үйл ажиллагааг төлөвлөлттэй байлгах
- системтэй байх

Үүнээс гадна дараах зарчимуудыг нэмж болох юм.

- аюулаас хамгаалах үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байх
- авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь аюулын нөхцөл байдалд тохирсон байх
- бүрэн хяналтанд байх
- уяан хатан, нөхцөл байдалд хурдан зохицох чадвартай байх
- эдийн засгийн хэмнэлттэй байх зэрэг зарчим байж болно.

Дүгнэлт

Ийнхүү "байгууллагын аюулгүй байдал" гэх ойлголт нь шинжлэх ухааны үүднээс нэн тэргүүний судлагдахуун болж байна.

Байгууллагын аюулгүй байдал гэдэг нь өргөн утгаараа байгууллагын эдийн засгийн эрх ашигт учирж болох аливаа аюулыг урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг саармагжуулан хүлээн зөвшөөрөгдөх доод түвшинд байлгаж чадах тогтолцоо юм.

Харин тодорхой, хязгаарлагдмал утгаараа бол үүсэж болох аливаа аюул занал, нэгэнт учирсан эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалах, арилгах, учирах

хор хөнөөлийг бууруулах, гэнэтийн элдэв учиралд үр ашигтай хариу үйлдэл үзүүлэхэд байгууллагын эзэмшиж байгаа бүх нөөцийг үр дүнтэй дайчлан ашиглах чадавхи юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хууль тогтоомжийн дагуу албадлагын шинж чанартай үйл ажиллагаа эрхэлж буй биеэ даасан субъект юм. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-нд байгууллага, албан тушаалтны аюулгүй байдлыг хангах чиглэлээр зүйл заалт оруулаагүй байна. Иймд төр, нийгмийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, албан тушаалтны аюулгүй байдлыг хуульчилж өгөх шаардлагатай цаг үе ирсэн гэж үзэж байна.

* * *